


БАТЛАВ.

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
21 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

  
Г. ОЮУНЧИМЭГ  
2020 оны 9 сарын 15 өдөр

БАТЛАВ.

МОНГОЛЫН ВОЛЕЙБОЛЫН ХОЛБООНЫ  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

  
Г. БАЯРСАЙХАН  
2020 оны 9 сарын 15 өдөр

Д ӨЛЗИЙХУТАГ БАГШИЙН НЭРЭМЖИТ НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ  
ВОЛЕЙБОЛЫН ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

2020 оны 09 сарын 15

Улаанбаатар хот

**1. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ**

Монголын волейболын холбоо

Хаяг: МҮОХ-ны байр, 402 тоот

Нийслэлийн Ерөнхий боловсролын 21-р сургууль

Чингисийн өргөн чөлөө,

Д.Өлзийхутаг багшийн шавь нар

Улаанбаатар 14210

Утас\Факс: 976-11-344340

Цахим шуудангийн хаяг: [info@mva.mn](mailto:info@mva.mn)

**2. ТЭМЦЭЭНИЙ ХУВААРЬ**

Тэмцээний өдрүүд:

2020 оны 10 сарын 16-аас 18-ны өдрүүдэд явагдана.

**3. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ ТЭМЦЭЭН БОЛОХ ГАЗАР**

Улаанбаатар хот, БЗД, 6-р хороо 21-р сургуулийн спорт зал (А,Б заланд)

**4. ОРОЛЦОХ БАГУУД**

4.1 Ерөнхий боловсролын сургуулиудын шигшээ багууд оролцоно.

4.2 Зохион байгуулагчид нь эрэгтэй, эмэгтэй багийн эцсийн мэдүүлэг, эрхийн төлбөр, мандатын баримтыг шалгасны үндсэн дээр тэмцээнд оролцох мандатыг олгоно.

**5. БАГИЙН МЭДҮҮЛЭГ БА МЭДЭЭЛЭЛ**

5.1 Оролцогч багууд мэдүүлгийн маягт, сурагчийн хувийн хэргийг эх хувиар нь авчирсан байна. (Тэмцээнд оролцохдоо хувийн хэргийг эх хувиар нь авч ирэх)

5.2 Техникийн зөвлөгөөн буюу шалгалтын үед эцсийн мэдүүлгийн маягт нийт 12 тамирчны бүрэлдэхүүнтэйгээр баталгаажуулна.

5.3 Багийн мэдүүлгийг сурагчдын лигийн тэмцээний мэдүүлгийн зааврын дагуу бэлдсэн байна.

5.5 Техникийн зөвлөгөөнд ирэхдээ багийн танилцуулгыг заавал авч ирнэ.

## **6. БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХЯНАХ, ТАЙЛАГНАХ БА СУДАЛГАА**

6.1 Зохион байгуулагчид нь МВХ-ны тэмцээн зохион байгуулах журмыг чандлан мөрдөнө.

6.2 Албан ёсны сугалааг 10-р сарын 13-нд 17:00-цагаас 21-р сургуулийн спорт залад болох техникийн зөвлөгөөний үеэр зохион байгуулна.

6.3 Техникийн зөвлөгөөнд ирэхдээ багууд эрхийн төлбөрөө (150,000₮) бэлнээр авч ирж сугалаанд оролцоно.

## **7. ТЭМЦЭЭНИЙГ ШҮҮХ**

7.1 Тэмцээнийг ОУВХ-ны тоглолтын дүрмийн дагуу болон МВХ-ны "Тэмцээн зохион байгуулах журмын" дагуу явуулна.

7.2 МВХ-ны Шүүгчдийн зөвлөлөөс томилогдсон шүүгчид тэмцээнийг шүүнэ.

## **8. ТЕХНИКИЙН ЗӨВЛӨГӨӨН**

8.1 Техникийн зөвлөгөөн дээр багийн дасгалжуулагч, ахлагч нар оролцоно.

8.2 Техникийн зөвлөгөөнийг Олон улсын волейболын холбооны дүрмийн дагуу удирдан явуулна.

## **9. АЛБАН ЁСНЫ ДҮРЭМ, БӨМБӨГ**

9.1. Олон улсын волейболын холбооны дүрмийн дагуу тэмцээнийг зохион явуулна. Тэмцээн эхлэхээс өмнө хийгдсэн Шүүгчдийн шалгалтын дүнгээр ямар нэгэн өөрчлөлт гарч болох ба Техникийн зөвлөгөөн дээр танилцуулна.

9.2. Тэмцээнийг MIKASA VolleyballMVA200 маркийн бөмбөгөөр явуулна.

## **10. ХУВЦАС**

10.1. Тоглолтын хувцас МВХ-ны стандартад нийцсэн байна. Баг тус бүр 2 өнгийн хувцастай байх ба зөвхөн нэрийн мэдүүлэгт баталгаажуулсан хувцсыг өмсөнө.

10.2. Хувцсыг буруу өмсөх, стандартыг дагаж мөрдөөгүй тохиолдолд дүрмийн дагуу торгууль хүлээнэ. (ОУВХ-ны Тэмцээн зохион байгуулах дүрмийн 19.5 дагуу)

10.3. Тоглолтын хувцсыг урьдчилсан шалгалтын үеэр шалгуулж баталгаажуулна.

10.4. Хажуугийн сандал дээр суух багийн албаны хүмүүс дараах шаардлагуудын аль нэгийг хангана:

- I. Багийн бүх гишүүдийн адил ижил өнгийн хувцас өмсөх
- II. Албан ёсны костюм өмсөж, зангиа зүүх

## **11. МАРГААН**

11.1. Тухайн тоглолт дууссанаас 30 минутын хугацаанд багийн менежер эсвэл ахлах дасгалжуулагч нь гомдол гаргах эрхтэй.

## **12. БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

12.1. Баг тус бүр 12 гишүүнтэй байна. Үүнд: 12 тоглогч, 1 дасгалжуулагч

### 13. САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ

- 13.1. Баг тус бүр дараах зардлыг хариуцна:  
а. Тэмцээнд оролцох эрхийн төлбөр баг тус бүр 150,000 төгрөг
- 13.2. Зохион байгуулах хороо нь:  
а. Тэмцээний залны түрээс болон зохион байгуулалтын зардал

### 14. ШАГНАЛ

- 14.1. Эхний 3 байр эзэлсэн багуудад Зохион байгуулах хорооноос цом, мөнгөн шагнал, медаль, диплом олгоно.
- 14.2. Тэмцээний статистикийг үндэслэн хамгийн шилдэг тоглогчдод тусгай шагнал олгоно.
- Үүнд:
- Шилдэг тэгш тоглогч - /Эр, Эм тус бүр нэг тоглогч/
  - Довтлогч - /Эр, Эм тус бүр нэг тоглогч/
  - Холбогч - /Эр, Эм тус бүр нэг тоглогч/
  - Хамгаалагч - /Эр, Эм тус бүр нэг тоглогч/
  - Хаагч - /Эр, Эм тус бүр нэг тоглогч/
  - Давуулагч - /Эр, Эм тус бүр нэг тоглогч/
  - Шилдэг дасгалжуулагч - /хоёр хүн/
  - Шилдэг шүүгч -/нэг хүн/

### 15. БОЛЗОШГҮЙ ЗҮЙЛ

- 15.1. Зааварт тусгагдаагүй гарч ирсэн асуудлыг зохион байгуулах хороо өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэнэ.

ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО  
Д.ӨЛЗИЙХУТАГ БАГШИЙН ШАВЬ НАР  
ХОЛБОО БАРИХ УТАС: 99297449, 80914000